

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ӨӨРИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ШААРДЛАГА, АРГА ЗҮЙ, ХЭЛБЭРҮҮД

Б.Наранбаатар*

*МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн эрхлэгч, доктор (Ph.D)

Түлхүүр үг: ОНМХ, сэтгүүлчийн ёс зүй, өөрийн зохицуулалт, ардчилал, чөлөөт хэвлэл, омбудсмен, хэвлэлийн зөвлөл, ёс зүйн алдаа, хариуцлага

Сэтгүүл зүй бол олон нийтийн эрх ашиг, мэдэх эрхэд үйлчилдэг мэдээллийн нээлттэй харилцаа. Энэ утгаараа үйл ажиллагаа нь тогтсон жор, дэг жаягаар явдаггүй. ОНМХ-ийн өнгө, дизайн, загвар шийдэл, мэдээллийг өгөх формат, хэлбэр нь хадгалагддаг боловч агуулга дахин давтагддаггүй. Жишээлбэл, олон сонин дундаас “Өнөөдөр” сонин нэр, лого, цаас, хэмжээ, ерөнхий дизайнаараа танигдах боловч, энэ хэвлэлийн яг ижил хоёр дугаар хэзээ ч гарахгүй. Өөрөөр хэлбэл, сэтгүүлч хүн өдөр тутам янз бүрийн сэдэв, үйл явдалтай тулж, өөр өөр хүмүүстэй уулзаж, ярилцаж, хийж бүтээх, бичих, нэвтрүүлэх мэдээлэл, контент нь агуулга, арга хэлбэрийн хувьд ялгаатай байдаг. Энэ нь нэг талаас уг мэргэжлийг сонирхолтой болгодог боловч, нөгөө талаас ажил, бүтээлд нь тавигдах хууль эрх зүй, ёс зүйн хэм хэмжээг тухай бүрд нь бодож, нягталж, хянаж явах шаардлага тулгардаг. Иймд олон төрөлт медиа контент үйлдвэрлэх, олон сэдэв чиглэлийн мэдээ, нийтлэл бичих явцад алдаа гарах тохиолдол бишгүй. Энэ нь сэтгүүл зүйн үйл ажиллагааг зохицуул-

даг хууль, эрх зүйн зохист орчны болон ёс зүйн хэм хэмжээг шийдвэрлэхэд ярвигтай болгодог.

Нийгэм-улс төрийн тогтолцоо, улс үндэстний эрх баригчдын бодлогын дүнд түүхэн тодорхой цаг хугацаанд хэрэгжиж буй хууль, эрх зүйн шаардлага нь заавал биелүүлэх статустай байдаг учир ОНМХ-ийн үйл ажиллагаа ч хүссэн, хүсээгүй шаардлага нийцэж байх ёстой. Өөрчлөх, сайжруулах санал гаргаж, хууль тогтоогч, нийгэм олон нийтэд нөлөөлж болно, гэхдээ хүчин төгөлдөр хуулийг бол биелүүлэх нь гарцаагүй.

Харин сэтгүүлчийн ёс зүйн асуудал нь энэ үүднээс нэлээд төвөгтэй үзэгдэл юм. Олон нийтэд зориулагдсан мэдээлэл бий болсон цагаас л мэдээлэгчийн ёс зүйн хэм хэмжээний тухай ойлголт урган гарсан. Энэ нь сэтгүүлч мэргэжил, мэдээллийн хэрэгсэл үүсэхээс хэдэн зуу, хэдэн мянган жилийн өмнөх хүний нийгэмтэй хамт хөгжиж ирсэн гэсэн үг. Хэзээ ч эцэслэн шийдвэрлэгдээгүй, хаана ч бүх нийтээр хүлээн зөвшөөрөөд хэрэглэгчид нэгдсэн “жор” гараагүй байгаа нь хатуу боловч үнэн. Харин шийдвэрлэх арга замуудыг санал болгодог, туршиж ирсэн, сайн туршлага хуримтлуулсан жишээ бол олон.

Сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах үндсэн механизм нь хэвлэлийн өөрийн зохицуулалт юм.

Мэдээж, сэтгүүлчдийн мэргэжлийн холбоод, тэдгээрээс гаргасан Ёс зүйн код, редакцын дотоод дүрэм, хувь сэтгүүлчийн мэргэжлийн бэлтгэл, ур чадвараас олон зүйл шалтгаалах боловч дээр дурдсан нөхцөлийн улмаас алдаа гарсаар байна. Алдаа гараагүй байсан ч сэтгүүлчийг, ОНМХ-ийг буруутган хуулийн хариуцлага хүлээлгэдэг, хүлээлгэхийг завдан төвөг учруулдаг тохиолдол ч элбэг. Учир нь сэтгүүлчид өдөр тутмын ажилдаа эрх мэдэлтэн, төрийн албан тушаалтнуудын буруутай үйл ажиллагаа, ёс зүйн алдааг шүүмжилдэг. Хийж буй ажлыг нь шүүмжлэхийг эрх мэдэлтнүүд хувь хүнийх нь нэр төрд халдлаа, гүтгэлээ, доромжиллоо гэж үзэж ойлгодог, гомдол гаргадаг жишиг их бий.

Иймд хэвлэлийн өөрийн зохицуулалт бол сэтгүүлчийн ёс зүйн хэм хэмжээ болон хүчин төгөлдөр хууль эрх зүйн шаардлага хоёрын дунд оршиж сэтгүүл зүйн болон иргэдийн эрх ашигт үйлчилдэг институт юм. Өөрөөр тодорхойлбол, хэвлэлийн өөрийн зохицуулалт гэдэг нь хэвлэл мэдээллийн салбарт ажиллагсад, редакцуудын хамтдаа сайн дураараа баталсан ёс зүйн зарчмыг олон нийтэд нээлттэйгээр мөрдүүлэх мэргэжлийн нийгэмлэг хэмээж болно.

Хэвлэлийн өөрийн зохицуулалтыг бий болгосон, бий болгодог олон арга хэлбэрүүд байдаг. Хамгийн түгээмэл нь мэргэжил, салбартаа үнэлэгдэж, хүлээн зөвшөөрөгдсөн сэтгүүлч, ОНМХ-ийн удирдлага, судлаач, иргэдийн төлөөл багтсан шинжээчдийн баг бүрдүүлэн Хэвлэлийн ёс зүйн зөвлөл байгуулах юм. Монголын Сэтгүүлчдийн нэгдсэн эвлэл Олон улсын сэтгүүлчдийн холбооны гишүүн. ОУСХ-ны Сэтгүүлчийн ёс зүйн кодекс Монгол Улсад хэрэгждэг гэсэн үг. Мөн МСНЭ-ээс

баталсан Сэтгүүл ёс зүйн зарчим /9 зүйлтэй/ бий. Монгол Улсад хэвлэлийн өөрийн зохицуулалтын байгууллага “Хэвлэл мэдээллийн зөвлөл” нэртэйгээр 2014 онд байгуулагдаж, Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим /10 зүйл, 32 заалттай/ баталсан. Бусад сэтгүүлчдийн холбоод, томоохон редакцууд ч дотооддоо даган мөрдөх зориулалтаар ёс зүйн кодуудыг баталж сахин мөрдөхийг уриалдаг. Үндсэндээ Монголын сэтгүүл зүйн салбарт сахивал зохилтой ёс зүйн хэм хэмжээ дээр дурдсан гурван баримтад туссан гэсэн үг.

Хэвлэлийн өөрийн зохицуулалт нь сэтгүүл зүйн салбарын өөрийн бий болгосон, хүлээн зөвшөөрсөн тодорхой байгууллагаар дамжин хэрэгждэг бөгөөд олон орны туршлагаас харахад санхүүжилт, эрх зүйн чадамж, зохион байгуулалтын хувьд хэд хэдэн янз байна. Нэрийн хувьд Хэвлэлийн консул, Хэвлэлийн зөвлөл, Хэвлэл мэдээллийн ёс зүйн зөвлөл, Хэвлэлийн омбудсмен зэргээр томъёологдох нь элбэг.

Хэвлэлийн өөрийн зохицуулалтын байгууллагын зорилгод дараах чиг үүргүүд багтсан байх нь түгээмэл. Үүнд:

- Бүх ОНМХ, редакц, сэтгүүлчдийг ёс зүйн хэм хэмжээг зөрчихгүй ажиллахад чиглүүлэх, сануулах, зөвлөн туслах, сурталчлан таниулах
- Сэтгүүлчийн нийтлэл, нэвтрүүлэгтэй холбоотой иргэн, хуулийн этгээдийн гомдлыг хүлээн авч, мэргэжлийн шинжээчдийн хувиар дүгнэлт гарган, тайлбар хийх
- Ёс зүйн алдаа гарсан тохиолдолд, өөрийн эрх зүйн чадамж, хүлээн зөвшөөрөгдөх хэм хэмжээнд нийцүүлэн сэтгүүлч, редакцад хариуцлага тооцож, олон нийтэд мэдээлэх

- Хууль, эрх зүйн хүчин төгөлдөр үйлчилж буй зохицуулалтын талаар сэтгүүлч, ОНМХ-ийн редакцад таниулах, зөвлөн туслах
- Хууль, эрх зүйн болон ёс зүйн хэм хэмжээний талаар сэтгүүлчдэд сургалт, семинар, арга хэмжээ зохион байгуулах
- Сэтгүүлчийн мэдээ, нийтлэл, нэвтрүүлэгтэй холбоотой иргэн, хуулийн этгээдийн гаргасан гомдлыг шүүхэд шилжүүлэхгүйгээр шийдвэрлэх, эвлэрүүлэн зуучлах, зөвшилцөл, ойлголцолд хүрэхэд туслалцаа үзүүлэх
- Хэвлэлийн эрх чөлөө, иргэний үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хангах чиглэлд нийгэм, олон нийт болон сэтгүүлчдэд чиглэсэн судалгаа, шинжилгээ, дүгнэлт хийж, сурталчлан таниулах гэх мэт.

Түүх сөхвөл, хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын анхны оролдлого хэлбэр үүсэх болсон шалтгаан нь: нэгдүгээрт, олон нийтийн зүгээс ирэх болсон гомдол, шүүмжлэл юм. Тогтмол хэвлэлийн хөгжлийн онцгой үе болох 19-р зууны хоёрдугаар хагаст АНУ, Англи зэрэг оронд хэвлэлийн салбарт арилжааны шинж давамгайлж, масс уншигчийн төлөөх өрсөлдөөн хурцадсанаар сэтгүүл зүйн зорилгоо “умартах”, хэн нэгэнд үйлчлэх, баримт зохиох, гүтгэх гэх мэтээр илт зохисгүй үйлдэл элбэг болсон байв. Энэ иргэдийн эсэргүүцэл, гомдолтой тулгарч, уншигчдын тогтмол хэвлэлд үзүүлэх итгэл үнэмшил буурснаар илэрсэн юм. Хоёрдугаарт, нөхцөл байдлыг ашиглан хэвлэл мэдээллийн нөлөөндөө оруулахыг зорьдог Төрийн субъект, улс төрчдийн оролдлого ч идэвхэжжээ. Иймд сэтгүүл зүй өөрөө өөрийгөө устгахаас, гаднын дарамт нөлөөнд бүр мөсөн орохоос сэргийлэхийн тул энэ

салбарынхан өөр хоорондоо тохиролцон, нийт сэтгүүлч, редакцууд дагаж мөрдвөл зохистой ёс зүйн хэм хэмжээг тодорхойлж эхэлсэн юм¹.

Харин хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын анхны байгууллага 1916 онд Шведэд Нэр төрийн шүүх буюу Хэвлэлийн зөвлөл нэртэйгээр бий болжээ.

Өдгөө ардчилал, хүний эрх, хэвлэлийн эрх чөлөөний хөгжлийн индексээрээ тэргүүлэгч улс орнуудад сэтгүүл зүйн салбарыг зохицуулах эрх зүйн нормыг аль болох багасгаж, сэтгүүлч, ОНМХ-ийн үйл ажиллагаатай холбоотой аливаа асуудлыг өөрийн зохицуулалтын байгууллагаар нь шийдвэрлүүлэх хандлага давамгайлж болж байна. Гэвч улс орон бүрд нөхцөл байдал харилцан адилгүй тул өөрийн зохицуулалтын байгууллагуудын эрх зүйн болон санхүүгийн чадамж өөр өөр байсаар ирлээ.

Ардчилсан тогтолцоо, хүний эрх, эрх чөлөөг тунхагласан орнуудад хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын байгууллагыг мэргэжлийн, бие даасан, хараат бус байхад илүү анхаарч, сэтгүүлчид, редакцуудын хандив, татаасаар санхүүжиж оршихыг эрхэмлэж иржээ.

Өөрийн зохицуулалтын чиг үүрэгтэй субъектүүдийг хэлбэрийнх нь хувьд ангилан тодорхойлж авч үзье.

1. Төрийн санхүүжилт, оролцоотой, тусгайлан баталсан хуулиар эрх зүйн чадамж нь баталгаажсан, засгийн газрын хэрэгжүүлэгч байгууллагын статус бүхий Хэвлэлийн консул/зөвлөл. Ийм хувилбар тухайлбал, 1993-2000 онд ОХУ-д Ерөнхийлөгчийн дэргэдэх Мэдээллийн маргааны шүүхийн танхим нэртэйгээр оршиж байв. Хэдийгээр мэргэжлийн сэтгүүлч, нэртэй

шинжээчдээс бүрдэж байсан боловч төрийн оролцоо хэтийдсэн ийм байгууллага сэтгүүл зүйд бус төрдөө үйлчлэх нь гарцаагүй.

2. Төрийн оролцоогүй буюу хязгаарласан санхүүжилт бүхий /50 хүртэл хувийн санхүүжилтээс төсвөөс авдаг боловч төрийн төлөөлөл зөвлөлдөө оруулдаггүй/, хуулиар эрх зүйн чадамж нь баталгаажсан хэвлэлийн консул/зөвлөл. Олон оронд байдаг өөрийн зохицуулалтын байгууллагын хувилбар. Ийм тохиолдолд тухай зөвлөл нь хэвлэл мэдээллийн салбарын “шүүх”-ийн үүрэг гүйцэтгэх бөгөөд сэтгүүлчийг торгох, лицензийг цуцлах, олон нийтийн ажил хийхийг албадах, үйл ажиллагааг зогсоох хүртэл хариуцлага оноох эрх мэдэлтэй байдаг.
3. Зөвхөн хэвлэл мэдээллийн салбараас хандив, татаасаар санхүүжиж, сайн дурын үндсэн дээр өөрийн зохицуулалтын үйл ажиллагаа эрхэлдэг, тусгайлан эрх зүйн чадамжийг тодорхойлсон хууль үгүй Хэвлэлийн консул/зөвлөл. Хамгийн түгээмэл хувилбар. Монголд 2014 онд байгуулагдсан Хэвлэл мэдээллийн Зөвлөл энэ загварт багтана. Энэ хувилбарын давуу тал нь мэдээж, сэтгүүл зүй болон олон нийтийн эрх ашигт нийцэж ажиллах боломж юм. Гэвч гол асуудал нь санхүүжилт дутмагаас үүдэн үйл ажиллагааны цар хүрээ хумигдах, хүртээмж бага байх, эрх зүйн чадамж сул учир гаргасан шийдвэр нь зөвхөн сануулах, олон нийтэд, зарлах, зөвлөн туслах зэрэг зөөлөн хэлбэрээр хариуцлага тооцдог оршино. Өөрөөр хэлбэл, үйл ажиллагааны үр нөлөө цэвэр сэтгүүлч, редакцуудын харилцан дэмжлэг, ойлголцлоос хамаарна.

4. Хэвлэлийн омбудсмен. Омбудсмен гэдэг нь Швед хэлний төлөөлөгч гэсэн утгатай үг. Олон хэлэнд энэ хэвээр төрөл бүрийн салбарт хэрэглэдэг нэр томъёо юм. Орчин үед сэтгүүл зүйн практикт ч омбудсмен хэмээх ойлголтыг өргөн хэрэглэх болжээ. Энэ бол сэтгүүл зүйн нийтлэл, нэвтрүүлэгтэй холбоотой гомдол, маргааны хянан шалгаж, дүгнэлт гаргах зөвлөл (алба) гэсэн үг юм. Омбудсмен бол шүүгч биш, түүнд өөрийн шийдвэрийн биелэлтийг шүүн таслах журмаар шаардах эрх мэдэл байхгүй. Шүүгчийн гаргадаг шиг мөрдөгдөж буй хууль дээр үндэслэсэн албан тогтоол гаргадаггүй. Харин тодорхой хэргийн мөн чанарыг мөрдөн илрүүлсэн үр дүнгээрээ л дүгнэлт гаргадаг². Зарим оронд хэвлэлийн омбудсмен нь мэргэжлийн шинжээчдийн баг, бүлэг байдаг. Харин АНУ, болон Скандинавын зарим хэвлэл мэдээллийн хэрэгсэл омбудсмен нэрээр редакцаа шинжээч нэг хүнийг ажиллуулдаг. Тухайн шинжээч нь редакцын үйл ажиллагаа, мэдээллийн бүтээгдэхүүнийг хөндлөнгийн ажиглагч, шүүмжлэгчийн хувиар санал, дүгнэлт өгч байдаг. Мөн ёс зүйн хэм хэмжээг ажлын явцад нь сахиулах, засварлах үүрэг ч оногдоно. Зарим редакцын дотоод дүрмээр омбудсменд дугаар эрхэлсэн редактораас ч илүү эрх мэдэл оногдох нь бий.

Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалт гэдэг бол хэвлэл мэдээллийн салбарынхан сайн дурын үндсэн дээр мэргэжлийн хэм хэмжээгээ тохиролцож, тэдгээрийг дагаж мөрдөхөд суралцах үйл явц юм. Энэхүү үйл явц нь олон нийтэд нээлттэй байдлаар явагддаг. Ингэснээр хэвлэл

мэдээллийн байгууллагууд мэргэжлийн түвшинд ажиллах, мөн олон нийтийн өмнө хүлээх хариуцлагаа ил тодоор хүлээн зөвшөөрөх чадвартайгаа харуулж буй хэрэг юм.

Хэвлэл мэдээллийн консул буюу өөрийн зохицуулалтын байгууллага нь мэргэжлийн хэм хэмжээг түгээн дэлгэрүүлснээрээ хэвлэлд итгэх олон нийтийн итгэл үнэмшлийг хамгаалан бататгадаг. Чөлөөт хэвлэл мэдээлэл гэдэг бол хариуцлагаас ангид хэвлэл мэдээлэл гэсэн үг биш гэдгийг олон түмэнд итгүүлж, тэдний дэмжлэгийг хүртэхэд өөрийн зохицуулалтын байгууллага тус болдог.

Нөгөө талаар өөрийн зохицуулалт нь мэргэжлийн алдаа дутагдлыг салбарын хүрээнд, мэргэжлийн хэм хэмжээний дагуу шийдвэрлэх боломжийг бий болгоно. Ингэснээр сэтгүүлчид шүүхийн хаалга татах, өндөр хэмжээний торгууль төлөх, тэр бүү хэл эрх чөлөөгөө хязгаарлуулах эрсдэлийг бодитой бууруулах боломжтой.

Олон нийтийн өмнө шүүмжлүүлж буй хэн бүхэн шүүмжлэлд эмзэг хандах нь түгээмэл байдаг. Тиймээс өөрийн зохицуулалтын байгууллага нь зүй ёсны гомдолд ажил хэрэгчээр хандах, хариу өгөх, алдаагаа засахад хэвлэл мэдээллийнхэнд туслах зорилготой юм. Алдаагаа хүлээн зөвшөөрөх нь мэргэжлийн түвшинд ажиллаж буйн тод илрэл болдог.

Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын байгууллагыг бий болгоход санаачилгатай оролцох хүмүүс бол юун түрүүнд хариуцлагатай сэтгүүл зүйн ач холбогдлыг ойлгож, ухамсарласан сэтгүүлч, редактор, хэвлэл мэдээллийн байгууллагын дарга нар байдаг. Хэвлэл



Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалт гэдэг бол хэвлэл мэдээллийн салбарынхан сайн дурын үндсэн дээр мэргэжлийн хэм хэмжээгээ тохиролцож, тэдгээрийг дагаж мөрдөхөд суралцах үйл явц юм. Энэхүү үйл явц нь олон нийтэд нээлттэй байдлаар явагддаг. Ингэснээр хэвлэл мэдээллийн байгууллагууд мэргэжлийн түвшинд ажиллах, мөн олон нийтийн өмнө хүлээх хариуцлагаа ил тодоор хүлээн зөвшөөрөх чадвартайгаа харуулж буй хэрэг юм



мэдээллийн салбарынхнаас гадна хариуцлагатай хэвлэл мэдээллийг эрхэмлэдэг олон нийтийн зүтгэлтэн, иргэний нийгмийн идэвхтэн, сонирхлын бүлгүүд болон хувь хүмүүс өөрийн зохицуулалтын тууштай дэмжигчид байдаг.

Сэтгүүл зүйн мэдээ мэдээлэл баталгаатай, үнэн байхыг хүсэн хүлээж, тийнхүү шаардах нь иргэдийн хувьд зүйн хэрэг. Тэгвэл сэтгүүлчдийн ёс зүйн дүрэм нь баталгаатай үнэн зөв мэдээллийг бэлтгэх

хийн тулд баримталбал зохих мэргэжлийн хэм хэмжээг ил тод болгож өгдөг. Харин ёс зүйн зөвлөл нь иргэдэд хүрч буй мэдээллийн “чанарын баталгаа” нь болно. Дундаж иргэний хувьд сэтгүүлчийн бүтээлийн талаарх гомдлоо өөрийн зохицуулалтын байгууллагад илэрхийлэх нь шүүхэд хандсанаас зардал чирэгдэл багатай байдаг. Улс төрчдийн хувьд ч ялгаагүй, гомдлоо шуурхай шийдвэрлүүлэх боломжтой байх давуу талтай. Үүнээс гадна хэвлэл мэдээллийн байгууллагууд алдаагаа олон түмний өмнө ил тодоор хүлээн зөвшөөрөх нь улс төрчдөд хамгийн чухал байдаг тул сэтгэл хангалуун

үлддэг. Ингэснээр чөлөөт хэвлэлийг дарамтлах, боомилох хүсэл эрмэлзлийг зөөлрүүлэн сааруулах боломжтой. Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалт нь төрийн хяналтад байдаг хэвлэл мэдээллийг иргэдийн хяналтад шилжүүлэх үйл явцыг хурдасгаж өгдөг тул ардчиллыг бэхжүүлэх чухал алхам болдог юм. Сайн хуультай байгаад ч, ёс зүйн хэм хэмжээтэй байгаад ч, хэвлэл мэдээллийнхэн олон нийтийн хүсэл сонирхлыг бүрэн хангаж чадахгүй. Чөлөөт хэвлэл мэдээлэл, тэр дундаа чанарыг эрхэмлэдэг мэдээллийн хэрэгсэл ч ялгаагүй өөрийн нийтэлж, нэвтрүүлсэн баримт, үзэл бодол, магад бусдаас ялгаатай байдлаараа үргэлж хэн нэгнийг эмзэглүүлж, хэн нэгний дургүйцлийг хүргэсээр байх болно³.

Өөрийн зохицуулалт нь ардчилал дахь хэл ам, дуулиан шуугианыг намсгаж бууруулахыг зорьдоггүй. Харин хэн бүхний хүлээн зөвшөөрч чадахуйц дундын хэм хэмжээг л бий болгож хөгжүүлэхийг хичээдэг. Нөгөө талаар үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө гэдэг бол бусдыг цочоох, тайван байдлыг нь алдагдуулах, эмзэглүүлэх эрхтэй салшгүй холбоотой гэдгийг улс төрчид болон олон нийт хүлээн зөвшөөрөхөөс аргагүй. Тийнхүү цочоож, эмзэглүүлэх шаардлагатай үед хамтаар хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээг дагаж мөрдөх нь сэтгүүлчдийн үүрэг, үүнд хяналт тавих нь өөрийн зохицуулалтын зорилго юм.

Нэг улсад хэвлэлийн өөрийн зохицуулалтын хэд хэдэн байгууллага зэрэгцэн орших тохиолдол ч бий. Хүлээсэн чиг үүргээрээ ялгарч болно. Тухайлбал, Их Британид Хэвлэлийн гомдол барагдуулах хороо нь санхүү, эдийн засгийн мэдээлэлтэй холбоотой чиг үүргээ салган бие даасан өөр зөвлөл байгуулсан. Орон нутгийн бие

даасан хэвлэлийн зөвлөл байгуулагдах нь түгээмэл бөгөөд Канадад гэхэд нийт 6 өөрийн зохицуулалтын байгууллага зэрэгцэн оршиж байна⁴.

Дүгнэн хэлэхэд, өөрийн зохицуулалтын байгууллага нь өнгөц харвал, сэтгүүлчийн ёс зүйн алдааг иргэний гомдлын дагуу хэлэлцэж, эсвэл алдаа гараагүйг иргэнд тайлбарлана, нөгөө бол алдаа гарсныг сэтгүүлчид сануулах, хариуцлага тооцох арга хэмжээ авдаг субъект юм. Өргөн утгаар нь харвал энэ нь чөлөөт хэвлэл, үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг сэтгүүл зүйн гал тогоо өөрөө хамгаалж, Төр, улс төрийн болон бизнесийн бүлгүүдээс хараат бус байх нөхцөлийг редакцууд хамтран бүтээх, туслан суралцах үйл явц аж. Ач холбогдол нь сэтгүүл зүйн бүтээлийн чанар сайжирснаар илэрч, үр нөлөөг нь сэтгүүлч, редакц, олон нийт хүртдэг чөлөөт, хараат бус хэвлэлийн “оршин тогтнох жор” юм.

Эшлэл

- 1 Рылова А.Н. Саморегулирование журналистики в Испании// Ибероамериканские тетради МГИМО. №2. Москва. 2015. стр 30.
- 2 Зулькафиль. М. Сэтгүүл зүйн тайлбар толь. УБ. 2005. 113-р тал
- 3 Хэвлэлийн өөрийн зохицуулалт гэж юу вэ? <http://www.mediacouncil.mn/a/5>
- 4 Рихтер А. Сэтгүүл зүйн үйл ажиллагааны зохицуулалтын олон улсын стандарт, туршлага. ЮНЕСКО – гийн хэвлэлийн газар. Москва. 2011. <http://www.unesco.org/new/fileadmin/MULTIMEDIA/FIELD/Moscow/pdf/MP5-CI/International%20Standards%20and%20Foreign%20Practices%20on%20Media%20Regulation.pdf>

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Зулькафиль. М. 2005. Сэтгүүл зүйн тайлбар толь. УБ.

2. Норовсүрэн Л. 2006. Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм. 3-р боть. УБ.
3. Чойсамба Ч. 2016. Сэтгүүлчийн ёс зүйн алдаа. УБ.
4. Рихтер А. 2011. Сэтгүүл зүйн үйл ажиллагааны зохицуулалтын олон улсын стандарт, туршлага. ЮНЕСКО – гийн хэвлэлийн газар. Москва.

Резюме

Автор данной статьи затрагивает вопросы о теоретической основе и функции

саморегулирования журналистики в целом, и его применения в Монголии. Особенное значение в статье дается анализу разных видов саморегулирования журналистики, и их эффективности. Также автор статьи заключает, что Саморегулирование СМИ улучшает качество их работы, повышает степень доверия к ним аудитории, а также помогает сохранять независимость в условиях давления со стороны государства и бизнеса.